

“Монлогистикс Холдинг” ХК-ийн Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн 2024 оны 03 сарын 12 -ны өдрийн
№24/ТУЗ/13 тоот шүүмэл
№2 дугаар хавсралтаар батлав.

МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК

УТГА
ATA11138-К 6381251
9023121052

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛЫН ЖУРАМ

Баримт бичгийн дугаар
[T2-TY3-06]

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	1
ХОЁР. КОМПАНИЙН ХУГАЦААТ ТАЙЛАНГ НИЙТЭД МЭДЭЭЛЭХ.....	1
ГУРАВ. ТУХАЙ БҮР НИЙТЭД МЭДЭЭЛЭХ МЭДЭЭЛЭЛ.....	3
ДӨРӨВ. НИЙТЭД МЭДЭЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ .	5
ТАВ. МЭДЭЭЛЛИЙН НИЙТЭД ХҮРГЭХЭД ТАВИГДАХ ХЯЗГААРЛАЛТ, ХАРИУЦЛАГА	6
ЗУРГАА. ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГҮҮД	6

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Зорилго

Энэхүү “Мэдээллийн ил тод байдлын журам” (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь “Монложистикс Холдинг” ХК (цаашид “Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдад Компанийн үйл ажиллагааны талаарх болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Зарчим

Компани нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, компанийн нууцад хамаарахаас бусад мэдээллийг нээлттэй, ил тод байлгах, мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэт, түргэн шуурхай мэдээлэх зарчмыг баримтлан ажиллана.

1.3. Компани нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ” гэх)-ны “Үнэт цаасны бүртгэлийн журам”, Монголын Хөрөнгийн бирж (цаашид “Бирж” гэх)-ийн “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”, Компанийн засаглалын кодекс болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв мэдээлэх үүрэгтэй.

1.4. Энэхүү журмын зүйл заалт нь холбогдох зохицуулагч этгээдээс баталсан дүрэм, журмын заалттай зөрчилдсөн тохиолдолд зохицуулагч этгээдийн дүрэм, журмыг дагаж мөрдөнө.

1.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, энэ талаар мэдээллийг зохицуулагч этгээдэд болон олон нийтэд хүргэхтэй холбоотой харилцааг Компанийн болон СЗХ-ны “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-аар зохицуулна.

1.6. Энэхүү журмын дагуу хөрөнгө оруулагч, олон нийтэд мэдээлэл түгээх албан ёсны хэл нь орчин цагийн Монгол хэл байх бөгөөд гадаадын хөрөнгө оруулагчдын мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор англи хэл дээр орчуулан хүргэж болно.

1.7. Энэхүү журамд тусгагдаагүй аливаа асуудлыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

1.8. Нэр томъёоны тайлбар

1.8.1. “Мэдээллийг нийтэд хүргэх” гэж Компани нь энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжид заасан мэдээллийг тогтоосон хугацаанд өөрийн болон Биржийн цахим хуудас, бусад олон нийтийн мэдээллийн болон харилцаа холбооны хэрэгсэл ашиглан олон нийтэд түгээхийг;

1.8.2. “Зохицуулагч этгээд” гэж Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржийг;

1.8.3. “Дотоод мэдээлэл эзэмшигч” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 77 дугаар зүйлд заасныг;

1.8.4. “Эрх бүхий албан тушаалтан” гэж Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-т заасан этгээдээс гадна ТУЗ-өөс эрх бүхий гэж тооцсон албан тушаалыг тус тус ойлгоно.

ХОЁР. КОМПАНИЙН ХУГАЦААТ ТАЙЛАНГ НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

2.1. Компанийн хугацаат тайлан нь хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны тайлан гэсэн хэлбэртэй байна.

2.2. Компани нь хагас жилийн үйл ажиллагааны тайланг жил бүрийн 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор цахим болон цаасан хэлбэрээр СЗХ-нд хүргүүлж, Компанийн болон Биржийн

- цахим хуудсанд байршуулна. Энэхүү ажлыг Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга удирдан зохион байгуулах үүрэгтэй ба мэдээллийн үнэн зөв, бүрэн бодитой байдлыг Компанийн Гүйцэтгэх захирал болон мэдээллийг бэлтгэн боловсруулсан албан тушаалтан хариуцна.
- 2.3. Компани нь хагас жилийн санхүүгийн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор Биржид хүргүүлэх ба Компанийн цахим хуудаст давхар байршуулна.
- 2.4. Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөгдсөн хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулсан аудитлагдсан санхүүгийн тайланг тайлант жил дууссанаас хойш 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор өөрийн болон Биржийн цахим хуудаст байршуулж, олон нийтэд хүргэнэ.
- 2.5. Журмын 2.2, 2.3-т заасан санхүү, үйл ажиллагааны хагас жилийн болон жилийн эцсийн тайланг тогтмол нийтэд мэдээлэхээс гадна улирал бүрийн тайланг бэлтгэн гаргаж, өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж болно.
- 2.6. **Компанийн жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайлан нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:**
- 2.6.1. Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл:
- 2.6.1.1. Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл;
- 2.6.1.2. Компанийн эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзлэх байр суурь;
- 2.6.1.3. Компанийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсч болох эрсдэлийн тухай мэдээлэл;
- 2.6.1.4. Тайлант хугацаанд Компанийн үйл ажиллагаанд гарсан томоохон үйл явдлын талаарх мэдээлэл;
- 2.6.1.5. Компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлын тайлан;
- 2.6.1.6. Нийгмийн хариуцлагын тайлан;
- 2.6.2. Удирдлагын талаарх мэдээлэл:
- 2.6.2.1. Компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;
- 2.6.2.2. Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл;
- 2.6.2.3. Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл;
- 2.6.2.4. ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны тайлан;
- 2.6.2.5. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан;
- 2.6.2.6. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийн талаарх үнэлгээний тайлан.
- 2.6.3. Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл:
- 2.6.3.1. Компанийн хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ;
- 2.6.3.2. Аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, түүний тайлбар тодруулга, дүгнэлт;
- 2.6.3.3. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл;
- 2.6.3.4. Тухайн жилийн санхүүгийн тайлангаар Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ болон хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцаа;

- 2.6.3.5. Жилийн туршид авсан зээлийн жагсаалт, түүний эргэн төлөлт болон барьцаа, баталгаа гаргасан талаарх мэдээлэл.
 - 2.6.4. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл:
 - 2.6.4.1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр;
 - 2.6.4.2. Компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл;
 - 2.6.4.3. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл: болон
 - 2.6.4.4. Компанийн эрх бүхий албан тушаалтан болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бусад компанийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг талаарх мэдээлэл.
 - 2.6.5. Ногдол ашгийн талаарх мэдээлэл:
 - 2.6.5.1. Компанийн ногдол ашгийн бодлого;
 - 2.6.5.2. Компанийн тухайн жилд хуваарилсан ногдол ашгийн хэмжээ, тарааж буй хэлбэр, хугацаа болон ногдол ашиг хуваарилаагүй тохиолдолд түүний үндэслэл шалтгааны талаарх мэдээлэл.
 - 2.6.6. Бусад шаардлагатай мэдээлэл:
 - 2.6.6.1. Энэ журам, СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын дөрөвдүгээр хавсралт, МХБ-ийн Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журамд тус тус заасан хугацаат мэдээлэл болон холбогдох хууль тогтоомжид заасан тухай бүр мэдээлэх шаардлагатай мэдээлэл;
 - 2.6.6.2. Компанийн шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.
- 2.7. Компанийн улирлын үйл ажиллагааны тайлан нь дараах мэдээллийг агуулсан байна.**
- 2.7.1. Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл:
 - 2.7.1.1. Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл;
 - 2.7.1.2. Компанийн эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзлэх байр суурь;
 - 2.7.1.3. Тайлант хугацаанд Компанийн үйл ажиллагаанд гарсан томоохон үйл явдлын талаарх мэдээлэл.
 - 2.7.2. Удирдлагын талаарх мэдээлэл:
 - 2.7.2.1. Компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;
 - 2.7.2.2. Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл;
 - 2.7.2.3. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны улирлын дүгнэлт;
 - 2.7.3. Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл:
 - 2.7.3.1. Компанийн улиралын санхүүгийн тайлан, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ;
 - 2.7.4. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл:
 - 2.7.4.1. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл
 - 2.7.5. Ногдол ашгийн талаарх мэдээлэл:
 - 2.7.5.1. Компанийн ногдол ашгийн бодлогод гарсан өөрчлөлт
 - 2.7.5.2. Компанийн тухайн улиралд хуваарилсан ногдол ашгийн хэмжээ, тарааж буй хэлбэр, хугацаа болон ногдол ашиг хуваарилаагүй тохиолдолд түүний үндэслэл шалтгааны талаарх мэдээлэл.
 - 2.7.6. Бусад шаардлагатай мэдээлэл:
 - 2.7.6.1. Компанийн шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

ГУРАВ. ТУХАЙ БҮР НИЙТЭД МЭДЭЭЛЭХ МЭДЭЭЛЭЛ

- 3.1. Компани нь энэхүү журмын 3.2-т заасан аливаа үйл явдал, өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухайн үйл явдал, өөрчлөлт болсноос хойш ажлын 1 өдөрт багтаан СЗХ, Биржид хүргүүлж,

Биржийн болон өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Энэхүү ажлыг Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга удирдан зохион байгуулах үүрэгтэй ба мэдээллийн үнэн зөв, бүрэн бодитой байдлыг Компанийн Гүйцэтгэх захирал болон мэдээллийг бэлтгэн боловсруулсан албан тушаалтан хариуцна.

3.2. Компанийн тухай бүр нийтэд хүргэх мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна. Үүнд:

3.2.1. Санхүүгийн мэдээлэл:

3.2.1.1. Компанийн хөрөнгө, өр төлбөр, хувьцаат капитал болон үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ хэлцэл байгуулах;

3.2.1.2. Компанийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувьд нөлөөлөх бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ хэлцлийг цуцлах, дуусгавар болох;

3.2.1.3. Компани хөндлөнгийн аудиторын байгууллагатай байгуулсан гэрээ, түүний нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээлэл; Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл;

3.2.1.4. Компанийн үл хөдлөх хөрөнгийн үнийн дүнгийн 10 ба түүнээс дээш хувьтай тэнцэх хөрөнгийг худалдах, барьцаалах болон бусад хэлбэрээр бусдад шилжүүлэх, битүүмжлэх, тусгаарлах;

3.2.1.5. Компани төлбөрийн чадваргүй болох;

3.2.1.6. Компанийн толгой, охин болон хараат компани өр төлбөрөө төлөх санхүүгийн чадваргүй болох; болон

3.2.1.7. Компанийн өрийг хувьцаагаар солих шийдвэр гаргах.

3.2.2. Санхүүгийн бус мэдээлэл:

3.2.2.1. Компанийн бизнесийн үйл ажиллагааны зарим хэсгийг охин, хараат компанид болон бусад этгээдэд шилжүүлэх, эсхүл хязгаарлах болсон;

3.2.2.2. Компани үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх, хувьцааны ханшид нөлөөлөхүйц шинэ бүтээгдэхүүн зах зээлд танилцуулах;

3.2.2.3. Үндсэн болон шинэ бүтээгдэхүүнд зориулан тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах эрх, барааны тэмдэг эзэмших болон цуцлагдах;

3.2.2.4. Компанийн оноосон нэр, үндсэн захиргаа болон толгой компанийн оршин байх хаяг байршил өөрчлөгдсөн;

3.2.2.5. Компани салбар, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах болсон талаарх мэдээлэл;

3.2.2.6. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагад орсон өөрчлөлт;

3.2.2.7. Нийт ажиллагсдын 15 болон түүнээс дээш хувьд өөрчлөлт орох буюу чөлөөлөгдөх, шилжих, шинээр ажилд орох;

3.2.2.8. Компани бусад компанийн хувьцааны хяналтын багц болон түүнээс дээш хувийг худалдах, худалдан авах болсон;

3.2.2.9. Хувьцааны опцион болон хувьцаа эзэмшигч компанийн хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрх бүхий нэмэлт хувьцаа гаргах шийдвэр;

3.2.2.10. Компани шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох;

3.2.2.11. Компанийг нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах зэргээр өөрчлөн байгуулах болон өөрчлөх шийдвэр;

3.2.2.12. Компанийн хувьцааг хуваах, нэгтгэх тухай шийдвэр;

3.2.2.13. Компанийг татан буулгах шийдвэр.

3.2.3. Удирдлагын талаарх мэдээлэл:

- 3.2.3.1. Компанийн ТУЗ-өөс гаргасан үнэт цаасны ханшид нөлөөлөх аливаа шийдвэр;
- 3.2.3.2. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл болон тэдгээрийн бусад компанид эзэмшиж байгаа хувьцаанд гарсан өөрчлөлт;
- 3.2.3.3. Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох;
- 3.2.3.4. Компанийн нийт гаргасан хувьцааны хяналтын багц эзэмшигчид болон эрх бүхий албан тушаалтнуудын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон.
- 3.2.4. СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын дөрөвдүгээр хавсралт, МХБ-ийн Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам болон холбогдох бусад хууль тогтоомжид тус тус заасан тухай бүр мэдээлэх шаардлагатай мэдээлэл.
- 3.3. Компани нь буруу, алдаатай, зөрүүтэй, төөрөгдөл оруулахуйц мэдээлэл нийтэд мэдээлсэн тохиолдолд түүнийг анх мэдээлэл түгээсэн арга хэрэгслээр нэн даруй засаж залруулах арга хэмжээ авна.
- 3.4. Олон нийтийг төөрөгдүүлсэн худал, ташаа мэдээлэл нийтэд тарж, компанийн бизнесийн нэр хүндэд нөлөөлөх нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн нөхцөл байдлыг олж тогтоох, тайлбар өгөх зэргээр шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.
- 3.5. Журмын 3.3, 3.4-т заасан арга хэмжээг Компанийн ТУЗ-ийн дарга болон Гүйцэтгэх захирал хариуцан зохион байгуулна.

ДӨРӨВ. НИЙТЭД МЭДЭЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ

- 4.1. Энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжид заасан нийтэд мэдээлэх хугацаат болон тухай бүр хүргэх мэдээллийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга СЗХ-нд хүргүүлж, Компанийн болон Биржийн цахим хуудсанд байршуулах үүрэгтэй.
- 4.2. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон холбогдох мэдээлэл түгээх ажилтнууд нь Журмын Хавсралт №1-ээр тогтоосон мэдээлэл дамжуулах, нийтэд түгээх суваг, дамтамж, дарааллыг баримтална.
- 4.3. ТУЗ нь хөрөнгө оруулагчдад биечлэн мэдээлэл түгээх зорилгоор хурал, уулзалт, арга хэмжээ зохион байгуулахаар шийдвэрлэж болно.
- 4.4. Зохицуулагч этгээдэд мэдээлэл нийлүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх албан тушаалтныг Гүйцэтгэх захирал тусгайлан томилж болно.
- 4.5. Компанийн мэдээллийг цахим хэлбэрээр нийтэд ил болгох ба зохицуулалттай этгээдэд нийлүүлэх мэдээлэл нь цаасан болон цахим хэлбэртэй байна.
- 4.6. Компани цахим хэлбэрээр мэдээлэл нийлүүлэхдээ Биржийн “Үнэт цаас гаргагчаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар”-ыг баримтална.
- 4.7. Биржийн цахим хуудаст хандаж мэдээлэл байршуулахад ашиглах нэвтрэх нэр, нууц үгийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эзэмшинэ.
- 4.8. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эзгүйд түүний эрх, үүргийг хуулийн нэгж хэрэгжүүлэх ба энэ тохиолдолд Биржийн цахим хуудаст нэвтрэх нэр, нууц үгийг шилжүүлж болно.
- 4.9. Биржийн цахим хуудаст нэвтрэх эрхийг зориулалтын бусаар ашиглах, бусдад дамжуулах, санаатай болон болгоомжгүй байдлаар алдах, задруулахыг хориглоно.
- 4.10. Журмын 4.1-т заасны дагуу цахим хуудаст хандаж мэдээлэл байршуулахтай холбоотой бэлтгэл үе шатанд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, хуулийн нэгж, маркетингийн нэгж болон бусад холбогдох нэгжтэй хамтран ажиллана.
- 4.11. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд нийтэд ил болгох мэдээллийн агуулга, хэлбэр, тэдгээрийн үнэн зөв, бодитой байдалд ТУЗ-ийн дарга хяналт тавьж ажиллах ба ТУЗ-ийн

- нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн даргаар хянуулахгүйгээр мэдээллийг оруулахыг хориглоно.
- 4.12. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга мэдээллийг хугацаанд нь, үнэн зөв, бүрэн нийлүүлж байгаа эсэх тухайгаа ТУЗ-д тайлагнаж ажиллах ба эцсийн хяналтыг ТУЗ хэрэгжүүлнэ.
- 4.13. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга томилогдсон, өөрчлөгдсөн тохиолдолд түүнийг томилсон тухай ТУЗ-ийн шийдвэр болон анкетыг Гүйцэтгэх захирал шийдвэр гарснаас хойш ажлын 1 хоногийн дотор зохицуулагч этгээдэд хүргүүлнэ.
- 4.14. Компанийн нэрийн өмнөөс мэдэгдэл, тайлбар хийх замаар олон нийтэд нэмэлт мэдээлэл хүргэж болох ба дараах албан тушаалтан Компанийг төлөөлнө. Үүнд:
- 4.14.1. ТУЗ-ийн дарга;
- 4.14.2. Гүйцэтгэх захирал;
- 4.14.3. ТУЗ болон Гүйцэтгэх захирлаас зөвшөөрсөн бусад албан тушаалтан.
- 4.15. Компаниас гарж буй аливаа мэдээллийг бүрдүүлэх, бэлтгэх ажлыг Компанийн холбогдох чиг үүрэг бүхий зохион байгуулалтын нэгж хариуцах ба мэдээллийн үнэн зөв, бодитой, хугацаанд нь байх шаардлагыг хангаж ажиллахаас гадна аливаа гуравдагч этгээдэд шилжүүлэх, алдах, гэмтээх, хуурамчаар үйлдэхээс урьдчилан сэргийлж ажиллана.
- 4.16. Компаниас гарж буй аливаа мэдээллийг үнэн зөв бэлтгэн, бүрэн гүйцэт, хугацаанд нь хүргүүлэхтэй холбоотой бүхий л үйл ажиллагаанд Компанийн эрх бүхий албан тушаалтнууд, ТУЗ хяналт тавьж ажиллана.

ТАВ. МЭДЭЭЛЛИЙН НИЙТЭД ХҮРГЭХЭД ТАВИГДАХ ХЯЗГААРЛАЛТ, ХАРИУЦЛАГА

- 5.1 Компанийн дотоод мэдээлэл эзэмшигч нь тухайн мэдээллийг энэхүү журамд заасны дагуу нийтэд мэдээлэхээс өмнө уг мэдээллийг санамсаргүй болон болгоомжгүй байдлаар задруулах, зөвшөөрөлгүйгээр мэдээлэх, дамжуулах, ашиглах, бусдад олж авах нөхцөлийг бүрдүүлэхийг хориглоно.
- 5.2 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон мэдээлэл нийлүүлэх үүрэг бүхий ажилтан нь төөрөгдүүлсэн, хуурамч, бүрэн бус мэдээллийг түгээх зөвшөөрөлгүйгээр олон нийтэд мэдээлэхийг хориглоно.
- 5.3 Энэхүү журмыг зөрчсөн ажилтанд Хөдөлмөрийн дотоод журамд заасан хариуцлага ногдуулна.
- 5.4 Журмыг зөрчсөн этгээдийн үйлдэл, эс үйлдэхүй нь холбогдох хууль тогтоомжид заасан Эрүүгийн болон Захиргааны зөрчлийн шинжтэй гэж үзвэл төрийн эрх бүхий байгууллагад мэдэгдэх, зохих байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авна.

ЗУРГАА. ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГҮҮД

- 6.1. Энэхүү баримт бичигтэй холбогдох бусад баримт бичгүүд:
- 6.1.1 Хөдөлмөрийн дотоод журам;
- 6.1.2 Албан хэрэг хөтлөлтийн багц журам;
- 6.2. Энэхүү баримт бичгийн хавсралтууд:

№	Хавсралтын нэр	Дугаар
1	Мэдээлэл түгээх суваг, давтамж	Хавсралт №1